



**ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.3, 76 дугаар зүйлийн 76.1.2, Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 02 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн а/823 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 12:30 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр, Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг хоёрдугаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг гуравдугаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

Тооллогын комиссын дарга: Л.Оюун-Эрдэнэ /Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга/

Гишүүд: Э.Мөнхшүр /Захиргаа, хүний нөөцийн албаны дарга/
Ж.Мөнх-Эрдэнэ /Дотоод хяналтын хэлтсийн дарга/

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэхийг томилсугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах өдрийг 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 25 -ны өдрөөр тус тус тогтоосугай.

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, холбогдох материалуудыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг гүйцэтгэх захирал /Л.Эрхбаатар/-д үүрэг болгосугай.


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

И.ЛУВСАНЦЭРЭН

1701040028

2546191 А ХНТ5448
УЛААНБААТАР ХОТ


Дулааны гуравдугаар цахилгаан станц ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар
сарын 18-ны өдрийн 09 дугаар тогтоолын
01 дүгээр хавсралт



Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны зардлын төсөв батлах тухай;
4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай;
6. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
7. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай;
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар
сарын 18-ны өдрийн 09 дугаар тогтоолын
02 дугаар хавсралт



“ДУЛААНЫ ГУРАВДУГААР ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД
САНАЛ АВАХ ХУУДАС

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 12:30 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд болно.

Хувьцаа эзэмшигчийн овог нэр:	Эрчим хүчний яамыг төлөөлж Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрыг төлөөлж Ц.Баяр-Эрдэнэ
Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар:	51263051
Хувьцаа эзэмшигчийн мэйл хаяг:	info@energy.gov.mn
Регистрийн дугаар:	
Эзэмшиж буй хувьцааны тоо:	Эрчим хүчний яам 66% Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 34%

Санал хураах арга: Энгийн

№	Санал авах асуудал	Зовшоорсон	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай	☐	☐	☐
2.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай	☐	☐	☐
3.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны зардлын төсөв батлах тухай	☐	☐	☐
4.	Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай	☐	☐	☐
5.	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай	☐	☐	☐
6.	Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;	☐	☐	☐
7.	Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай	☐	☐	☐
8.	Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал	☐	☐	☐

Заавар: Та өөрийн саналыг + тэмдгээр бичнэ үү.

Хувьцаа эзэмшигчийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн Нэр..... ЭХЯ 66% ТӨБЗГ 34% Албан тушаал..... Гарын үсэг.....	
Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг	
Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг	/...../

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах):

Тийм

Үгүй

Комиссын дарга: / Л.Оюун-Эрдэнэ /


Гишүүд: / Э.Мөнхшүр /

..... / Ж.Мөнх-Эрдэнэ /

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

.....
.....
.....

Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар
сарын 18-ны өдрийн 09 дүгээр тогтоолын
03 дугаар хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК
Хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо “ДЦС-3” ТӨХК-ийн байр
Хурал хуралдах өдөр, цаг:	2025.04.29-ны өдөр, 12:30 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Эрчим хүчний яам /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр /
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2025.03.18
Олон нийтэд зарлах огноо:	2025.03.24
Бүртгэлийн өдөр:	2025.04.10
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2025.03.21
Хүргүүлсэн огноо:	2025.03.21
Хурлын даргын нэр:	Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Тавинбэх
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Комиссын дарга: Л.Оюун-Эрдэнэ, Гишүүд: Э.Мөнхшүр, Ж.Мөнх-Эрдэнэ
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	• Хурал хуралдуулах тухай шийдвэр • Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээллэх зарын загвар • Саналын хуудасны загвар • Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа
Баримт бичгийн хуудасны тоо:	 ширхэг
	... хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

2025 оны дугаар сарын-ны өдөр

Дулааны гуравдугаар цахилгаан станц" ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар
сарын 18-ны өдрийн 09 дугаар тогтоолын
04 дүгээр хавсралт

**“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар**

Компанийн оноосон нэр: “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо “ДЦС-3” ТӨХК-ийн байр

Хурал хуралдуулах газар, өдөр, цаг: “Эрчим хүчний яам”-ны хурлын танхимд 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 12:30 цагт

Бүртгэлийн өдөр:

2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны зардлын төсөв батлах тухай;
4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай;
6. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
7. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай.
8. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам:

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн 08:00-17:00 цагийн хооронд 99008424 утсаар болон “Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн төв байранд ирж, ТУЗ-ийн нарийн бичгийн даргатай уулзан танилцаж болно. Мөн электрон хэлбэрээр авч танилцаж болно.

Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ХЭХ хуралдуулах шийдвэр
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх “Саналын хуудас”
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалууд
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл
5. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлан

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн
 ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт
 болон тэдгээрийг бэлэн болгох хугацаа**

№	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл	Бэлэн болох хугацаа
1.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол	2025.03.18
2.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл	2025.03.18
3.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар	2025.03.24
4.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас	2025.03.18
5.	Компанийн 2024 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан	2025.04.01
6.	Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2024 оны үйл ажиллагааны тайлан, компанийн санхүүгийн тайланд өгөх дүгнэлт	2025.04.01
7.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны зардлын төсөв	2025.04.01
8.	Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр	2025.04.01
9.	Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн танилцуулга	2025.04.01

**“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг**

“Дулааны гуравдугаар цахилгаан станц” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 12:30 цагт “Эрчим хүчний яам”-ны хурлын танхимд болно.

№	Хурлын дараалал	Гарах шийдвэр	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Бүртгэлийн үйл ажиллагаа - Хурлын ирцийг бүртгэх, мэдээлэх		1 минут	Тооллогын комисс
2.	Хурлын нээлт -Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах		1 минут	Хурлын дарга
3.	Хэлэлцэх асуудал-1 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах -Асуулт /1хүн 2 минут/, хариулт	Тогтоол	5 минут	Гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар
4.	Хэлэлцэх асуудал-2 Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах -Асуулт /1хүн 2 минут/, хариулт	Тогтоол	5 минут	ТУЗ-ийн дарга И.Лувсанцэрэн
5.	Хэлэлцэх асуудал-3 Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны зардлын төсвийн төсөл танилцуулах -Асуулт /1хүн 2 минут/, хариулт	Тогтоол	3 минут	ТУЗ-ийн дарга И.Лувсанцэрэн
6.	Хэлэлцэх асуудал-4 Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах -Асуулт /1хүн 1 минут/, хариулт	Тогтоол	3 минут	ТУЗ-ийн дарга И.Лувсанцэрэн
7.	Хэлэлцэх асуудал-5 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай -Асуулт /1хүн 1 минут/, хариулт	Тогтоол	2 минут	Нэр дэвшүүлэх хорооны дарга Д.Чимэдлхам
8.	Хэлэлцэх асуудал-6 Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай-Асуулт /1хүн 1 минут/, хариулт	Тогтоол	3 минут	ТУЗ-ийн дарга И.Лувсанцэрэн
9.	Хэлэлцэх асуудал-7 Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай -асуулт /1хүн 1 минут/, хариулт	Тогтоол	3 минут	ТУЗ-ийн дарга И.Лувсанцэрэн

10.	Хэлэлцэх асуудал-8 Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал. -асуулт /1хүн 1 минут/, хариулт	Тогтоол	3 минут	Гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар
11.	Санал хураалт		2 минут	Тооллогын комисс
12.	Хурал хаах		1 минут	Хурлын дарга

_____ оОо _____